

УТГА ЗОХИОЛ, УРЛАГ

**ОРЧИН ҮЕИЙН ХЯТАДЫН УТГА ЗОХИОЛЫН
ХУВЬ ЗАЯА**

Хятадад 1966 оны тавдугаар сард Мао Зэдуны шууд санаачлага удирдлагаар «аугаа их пролетарийн соёлын хувьсгал» гэгч эхэлж энэ орныг нийгэм-улс төр-эдийн засаг оюун санааны мөхөл сүйрлийн даваан дээр хөтлөж аваачсаныг 16 жил өнгөрсний дараа бээжингийнхэн хүлээн зөвшөөрч байна.

Маоист «соёлын хувьсгал» гэгч бол устган сүйтгэх, соёл, урлагийн зүтгэлтнийг бараг толгой дараалан харгислах, ном зохиолыг шатаах ажлаар эхлэснийг дэлхий дахин мэднэ. Энэ тухай нэг талаар элэг эмтэрмээр, нөгөө талаар инээд хүрмээр өгүүлэл сүүлийн жилүүдэд хятадын хэвлэлд ч гардаг боллоо. Үүнд 1979 оны 9-р сарын 8-нд «Гуанмин жибао» сонинд нийтэлсэн «Аугаа их соёлын хувьсгалын үед Ля Юаньжан хилс хэрэгт баривчлагдан шоронд хоригдсон юм» гэсэн өгүүллийг хэлж болно.

«Саяхан би нэг дайллаганд очоод хэмхэрхий сандал дээр суучихжээ. Тэгээд би шал дээр нураж ойчихдоо (дөрвөн дээрэмчин) гэж хашгирахад тэнд байсан хүмүүс үхтлээ инээлдэж билээ» гэж канадын нэг сурвалжлагч ярьсныг америкийн жүжгийн зохиолч Артур Миллер хятадын тухай бичсэн туужиндаа дурджээ.

«Соёлын хувьсгалыг» «их залуурчийн» заавраар гардаж хийж байсан улаан хамгаалагчид хятадын ард түмний мянган жилийн соёлын өв уламжлалыг устгаж, шинжлэх ухаан, соёлыг үзэн ядаж, хүчирхийллийг хүний амьдралын цорын гагц хөдөлгүүр гэж зарлаж байв. Түүнийг зөвхөн зарлаад зогсоогүй идэвхтэй хэрэгжүүлсэн юм. БХАТХ-ын Байнгын Хорооны гишүүн Жун Ижэний хэлснээр «соёлын хувьсгалын» жилүүдэд бүрэн биш мэдээгээр 8-10 сая хүн алагдаж, 200 сая хүн мөрдөгджээ. 20 сая залуучууд сурч боловсрох боломжоо алдаж алс зэлүүд нутаг районд цөлөгджээ. Ийм өргөн их цар хүрээтэй харгислал хавчлага аль ч улсын түүхэнд бараг тохиолдож байгаагүйг түүх мэднэ.

Тэр хэдхэн жил үргэлжилсэн аюумшигт компанийн явцад хятадын ард түмний олон арван үеийн соёл нь уг соёлыг цаашид хөгжүүлж байсан хүмүүсийнхээ хамт сүйдэж сүйрсэн юм.

«Соёлын хувьсгал» эхэлмэгцээ хятадын томоохон зохиолч Лао Шэг амь насаа алдахад хүргэж, нэрт зохиолч Жао Шули 1970 оны 9-р сард хөнөөгдлөө. Маогийн харгис хэрцгий бодлого, явууллагыг илт эсэргүүцсэн зоригт хүмүүс ялангуяа хятадын зохиолчдын дотор цөөнгүй бий юм. Жишээ нь ХКН-ын Ляонин мужийн хорооны суртлын хэлтсийн ажилтан агсан эмэгтэй Жан Жисинь олон түмнийг хавтгайруулан харгислаж хяхах явдлыг илэрхий эсэргүүцмэгц түүнийг эхлээд «тавдугаар сарын 7-ны сургууль» гэгчид давтан хүмүүжүүлэхээр шилжүүлжээ. Гэтэл тэр эмэгтэй бурангуй ёс, «ангийн тэмцэл» гэгч халхавч бүхий фашист яргалалын эсрэг эвлэршгүй тэмцсээр байхлаар 1969 оны есдүгээр сард түүний хоёр гарыг

гавлаж Шэньяны гянданд шилжүүлэн бүх насаар нь хорих ял заажээ. Уг хэрэг үүгээр дууссангүй. 1975 оны дөрөвдүгээр сард Жан Жисиньд буудан алах ял зааж, түүнийг цаазлахын өмнө үг дуугаруулахгүйн тулд мөгөөрсөн хоолойг нь огтолсон байжээ.

«Соёлын хувьсгалын» халуун тамыг нэрт яруу найрагч Ай Цин, зохиолч эмэгтэй Дин Лин, тэдний дараагаар залуу үеийн авьяаслаг зохиолч Лю Биньянь, Цинь Жаоян, Ван Мэн зэрэг олон зохиолч туулжээ. Ван Мэнийг бүр 1956 онд «Жэньминь вэньсюэ» сэтгүүлд «Зохион зааварлах хэлтсийн шинэ ажилтан» гэсэн өгүүлэл нийтлүүлж бодит явдлыг урвуулж гүтгэлээ гэж 1957 онд бээжингийн утга зохиолын сэтгүүлийн редакцийн ажилчдын хурлаар бүтэн долоо хоног шүүмжлэж түүнээс хойш Ван Мэний бүтээл хэвлэлд гарахаа больжээ. Түүний өгүүллэгийг сэтгүүлдээ нийтэлсэн Цинь Жаоян ч бас хэрэг буруутаж өмнөд хятадын Гуанси мужид цөлөгджээ.

Ван Мэний тухайд гэвэл арван нэгэн настай байхдаа 8-р армид байлдаж, арван дөрвөн настайдаа коммунист намд элсч, намын нууц ажил хийж явсан зохиолч юм. Ван Мэн 1979 онд л сая Бээжинд буцаж ирэх эрхтэй болжээ.

«Соёлын хувьсгалын» догшин шуурганд хэлмэгдэгсдийн хамт янз бүрийн үед тамлагдсан «гэмтнүүд»-ийг ч бас цагаатгаж байна. Ай Цины ёжлон хэлснээр: «одоо хамаг юм хуучирч, үхэгсдийн дурсгалд зориулсан гашуудлын цуглаан хийж, цөм л сайн найз нар болж амьд цэцэг тавьцгааж байна. Урьд мөрдөж байцааж байсан хүмүүс ч амь үрэгдэгсдийн булшин дээр гашуудлын үг хэлж байж юу магад». «Соёлын хувьсгалаар» зөвхөн зохиолчид төдийгүй утга зохиолын сэтгүүлүүд нэг адил ширвэгджээ. «Жэньминь вэньсюэ», «Шикань» сэтгүүлийг дөнгөж 1976 оны нэгдүгээр сард сэргээлээ.

«Соёлын хувьсгал» шувтарснаас хойш хятадын утга зохиолын амьдралд нааштай ахиц багагүй гарлаа. 1981 оны мэдээгээр төв, хөдөөд хэвлэгдэн гарч буй утга зохиолын сэтгүүлийн тоо 634 болжээ. Эдгээрийн хуудсанд хятад орон, хятадын ард түмний үзэж амссан эмгэнэлт явдлын тухай өгүүлсэн зохиол олонтой гарч байна.

«Соёлын хувьсгал» мэт аюулт хэрэг явдал дахин үүсэх бий гэдэг түгшүүрт бодол хүн бүрийн дотор гүнзгий шингэж, сэтгэлийнхээ үгийг эрс тууш илэрхийлэх цаг үе хараахан болоогүй учраас санаагаа бүрхэгдүүлэх, тухайн байдалд зохицох, цагийн аясыг дагах байдал сүүлийн үеийн зохиол бүтээлийн нэг онцлог шинж болсоор байна.

Ямар ч л байсан 1977 оноос хойш хэвлэгдсэн хятадын зохиолчдын бүтээл «аугаа их гай гамшигийн арван жил» хийгээд түүний өмнөх үеийн байдал, мао болон түүний «сацрангуй» номлол зааврыг хэрэгжүүлэгчдийн өдүүлсэн гэмт хэргийг шууд биш боловч уран зохиолын аргаар дүрслэн үзүүлэх эрмэлзэл дүүрэн байгаа нь харагдаж байна. Утга зохиолын энэ чиглэл нь нэгэнт өнгөрсөн боловч ул мөр нь арилах яагаа ч үгүй байгаа «соёлын хувьсгалын» цуст хөрсөн дээр торнин бойжиж байна. Нэг үгээр хэлэхэд бэлэн жороор маоист улаан хамгаалагчид, тэдний жолоодогчдын захиалгаар бичдэг байсан утга зохиолын оронд хятадын ард түмний амсаж өнгөрүүлсэн гашуун зовлонг дүрслэн гаргах сэтгэл зүрхний дуудлагаар бичсэн реалист чиглэлийн утга зохиол бий болж эхэлж байна.

Зохиолын сэдэв өргөжиж амьдралын шинэ шинэ асуудлыг хамарч байгаа боловч «соёлын хувьсгалын» сэдэв хятадын утга зохиолд цаашид байсаар байх нь мэдээж бөгөөд үүнийг «их үсрэлт», «соёлын хувьсгал»

мэт аюумшигт явдлыг дахин гаргуулахгүй байх гэсэн хүн ардын чин эрмэлзэл шаардаж байна. «Хэдийгээр манай нийгэмд шившигтэй бузар булай үзэгдэл байсаар байгаа боловч бид хүмүүсийг хайрлаж тэдэнд бүрэн итгэж, зохиол бүтээл маань хичнээн хязгаарлагдмал, цаг зуурын чанартай байлаа ч гэсэн сайн нөлөө үзүүлнэ гэж найдаж байгаагаа» Ван Мэн илэрхийлжээ. Энэ үг орчин үеийн хятадын дэвшилт зохиолчдын санал бодлыг тодорхой илэрхийлж байна.

Яруу найрагч Хэ Зинжи 1981 оны тавдугаар сарын 21-нд «Гуанмин жибао» сонинд нийтэлсэн «утга зохиол, урлагийн талаар одоогийн зохиож буй ажлын тухай хэдэн санаа» гэсэн өгүүлэлдээ улс төрийн талаар хавчиж хяхах явдлыг шууд буруушаажээ. Гэтэл тийм зэмлэл хавчлагыг зарим нэг хүмүүс биш, албан ёсны хэвлэл хийсээр байна. Үүний нэг жишээ бол зохиолч Бай Хуагийн бичсэн «Гашуун дурлал» гэдэг кино зохиолыг армийн төв хэвлэл «Зефаньзюнь бао» сонин эрс шүүмжилсэн явдал юм. Энэ сонины өгүүллийн хэллэг нь улаан хамгаалагчдын хэвлэлээс төдий л ялгагдахгүй байгааг зөвлөлтийн утга зохиол судлаач, хятадач эрдэмтэн Л. Эйдлин онож тэмдэглэжээ. Энэ нь үнэний тухай үг жижүүрийн хараал зүхлээс уран бүтээлийн үндэс болон хувирч байгааг харуулж байгаа боловч хятадын утга зохиол цаашдаа чухам яаж хөгжихийг одоогоор хэлэхэд эрт байна.

Сүүлийн жилүүдэд хятад оронд гарч байгаа утга зохиолын бүтээлийг уншигч олонд танилцуулахын тулд зөвлөлтийн «Иностранная литература» сэтгүүлийн 1981 оны 11 дэх дугаарт хэвлэсэн хятадын нэг зохиолчийн өгүүллэгийг орчуулж дор нийтлэв.

Хэл

Сюй Мэнцигийн сэтгэлийн гал бадарч дүрэлзсээр байгаад хамаг биений нь шим шүүс аль эрт хатчихсан болохоор хэл нь дандаа зузаан өнгөртдөг байжээ. Тэгээд Сюй өдөр бүр өглөө, орой шүдээ цэвэрлэж дуусаад тогтмол хэлээ хусдаг заншилтай болжээ.

Тэр нэгэн дурсгалт өглөө Сюй Мэнци босч, нүүр гараа угаачихаад, хэлээ дахиад л толинд хартал шөнөдөө түлэгдсэн шарвин шиг улам ч зузаан хүрэн бор өнгөр тогтоод ам нь хув хуурайхан...

...Сюй шүдний сойзтой хамт аяганд хийж тавьсан нимгэн хусуурыг авч шалихгүй матийлган бариад заншил болсон ажлаа эхлэхээр бэлтгэтэл ганц дан байшингийн нь цонхон тушаа гэнэт нүргээнтсэн их дуу гарлаа. Цонхоор өнгийн харахад тэндээс холгүй газар барилгын ажилчид талбай тэгшилж байв. Тэд ямар нэг байшингийн ханыг урт ган аргамжаар бүслүүрдэн оосорлож, үзүүрийг нь тракторт уяад зүтгүүлэхэд нөгөө хана булгаран унаж, онгорхой цонхоор нь элс шороо бургилан баагиж байв. Сюй шүдээ цэвэрлэхээ болиод цонхоо бушуухан хаачихаад эхнэр лүүгээ эргэн харж:

-Яахлаараа эд нар сургуулийн ханыг гэнэт эвдлэх болсны учрыг чи мэдэж байна уу? гэж асуулаа.

Нөхрийнхөө үдийн хоолыг бэлтгэн поолуунд хийж суусан гэргий Ли Шуйжу:

-Өөрийнхөө ажлыг яая гэж байхад өрөөл бусдын юмыг харж байх зав чөлөө алга! гэж уцаарлав.

-Энэ чинь тэгэхлээр хошууны хувьсгалт хорооны даравгар Ван л энд «өргөөгөө» бариулах гэж талбай цэвэрлүүлж байгаа хэрэг байх нээ?! харж л байя гэж Сюй Мэнци дурамжхан янзтай бэвтэгнээд зэвэрдэггүй уян нимгэн хусуураа дахин матийлгаж толинд хэлээ харсаар хусаж эхлэв.

Тэгэхэд нь Ли Шуйжу уурлаж, нөхөртэйгээ үг зөрөхлөөр сандал ширээгээ харжигнуулж эхэлдэг зан нь хөдөлж дээр нь поолуутай хоол тавьсан ширээг тархийтэл ёвроод:

-Тэр муу Ван үхэж хатаж байсан ч чамд ямар хамаатай юм бэ?! Наад урт хэлээ юм болгонд дүрж л байгаарай! гэв.

-«Наад урт хэлээ» гэдэг чинь юу гэсэн үг вэ? гээд Сюй Мэнци эргэн харж: -- Даравгар Ваныг мууллаа гэж хэлэх нь үү?! Түүнийг ямар хүн гэж санана? Аль нэг хошууны хувьсгалт хорооны толгойлогч ухаантай жулдырай амьтан байж дөрвөн өрөөтэй байр нь багадаж, өөртөө шилтгээн өргөө бариулах гэж эрх тушаалаа ашиглан, сургуулийг өөр газар шилжүүлж, бас тэгээд хашааг томсгож, манай ногооны талбайн нилээд хэсгийг тасалж авч байгааг харахгүй юу... Ингэж байхаар өргөн олон түмэн ажилчин, албан хаагчид яах ёстой юм болж байнаа? Эх эцгүүд хүүхэд багачуул, ач гуч нартайгаа ганц ханзан дээр овоорч байх нь түүнд огт падгүй байхнээ? Энэ бол чиний бодлоор зөв үү? үгүй юу? чи хэл л дээ! гэж яг л даравгар Вантай хэрэлдэж байгаа юм шиг авгайнхаа нүүрийг шагайн хашгачив. ..

Зах хязгааргүй шахам нэлгэр том хашаанд хүмүүс дүүрч, зарим нь нүүр гараа угааж, өглөөний цайгаа ууж, зарим нь ус зөөж, эрэгтэйчүүлийн чанга чанга ярилцах дуу энд тэндгүй сонсдоно. «Үхэх дур чинь хүрээ юү?» гээд Ли Шуйжу ухасхийн очиж гадаа үүдээ хаав.

-Хэрэв үнэн юм гэж байдаггүй бол түүнийг бүр хүн амьтанд дуулдахаар хэлэх хэрэгтэй. Би юунаас ч айхгүй! Хүн нэг л үхдэг хойно...гэж Сюй Мэнци дуугаа улам чангалав.

-Дурлаад байвал үхэх чигээрээ үх! Харин гэр бүлдээ чи битгий балаг тариад бай. Чи ч бүр засаршгүй зантай хүн юм. Естой л хувьсгалын эсэргүү гэдэг ийм байдаг байх!

«Хувьсгалын эсэргүү» гэсэн үг аюулхай руу нь зүү шаах шиг болж айж цочсондоо Сюй Мэнцигийн хамаг бие дагжиж агшин зуур сульдаад ханзны буланд гөлрөн зогсов. «Чухамдаа хүний зан төрхийг өөрчлөж болохгүй» гэсэн гүн ухаантны сургаалыг сэтгэж, айхдаа «Ямар нь дандаа хэл амыг минь татаж чангаагаад байдаг байна?!» гэж аман дотроо өөрийгөө зэмлэв.

Соёлын хувьсгал болохоос өмнө Сюй Мэнци хошууны ардын боловсролын хэлтсийн даргаар ажиллаж байжээ. Түүний орлогчоор даравгар гэж хэлтсийнхэндээ хочлогдсон Ван Фэнтун ажиллаж байв. Тэрээр дуулсан мэдсэн бүхнээ ний нуугүй ярьдаг баараггүй найз нь байжээ. Тэгээд ч 1965 оны арван нэгдүгээр сард Шанхайн «Вэнь-хуайбао» сонинд «Хай жуй огцорч байна» хэмээх түүхэн драмын шинэ хувилбарын тухай» өгүүлэл хэвлэгдэхэд түүнийг Сюй Мэнцигийн баараггүй найз уншаад «Эш хөө, энэ өгүүллийн цаана нэг л хүн байх шиг байна. Энэ Яо Вэньюан¹ гэдэг чинь ер нь ямар шүү хүн байна?» гэж асуужээ.

Харин Сюй Мэнци бол утга зохиол их сонирхдог, утга зохиолын хэд хэдэн сэтгүүл захиалдаг, утга зохиол, урлагийн ертөнцийн нийтэд төдий л дэлгэрч мэдэгдээгүй нарийн ширийн хов живийг улс амьтанд ярихдаа дуртай хүн байв. Тэгээд ч Сюй: «Яо Вэньюан Яо Пэнзыгийн хүү юм. Түүний эцгийг урвагч байсан гэж Лу Синь гуай дурдсан удаа бий. Яо Вэньюан өөрөө бол ямар нэг утга зохиолын хэвлэлийн газар редактороор ажилладаг, шүүмж бичдэг юм. Түүний бичсэн юмыг үзэхэд хир баргийн юмыг

1. Яо Вэньюан бол «соёлын хувьсгалыг» толгойлж явсан нөгөө «дөрвөн дээрэмчин»-ний нэг юм. У ханийн «Хай Жуй огцорч байна» гэсэн драмын жүжигт зориулж бичсэн өгүүлэл нь санал бодол үл нийлэгсдийг довтлох харгис дохио болсон бөгөөд түүнийг нь Мао Зэдун сайшаасан ажээ.

тэсгээхгүй хүн шиг байгаа юм!» гэж нөхрийнхөө асуултад дуртайяа хариулжээ.

Тэр үед уг өгүүлэл Сю Мэнци, түүний найз Ван Фэнтун хоёрын аль алинд жирийн сэдвээр жирийн нэг хүний бичсэн аятайхан шүүмж шиг санагдаж байжээ. «Одоо цаг агаар яасан сайхан байна!» гэсэн үгэнд ч сэжигтэй юм алга байв. Аугаа их соёлын хувьсгал ид гаарах үед шилдэг сайн найз нь энэ үгний улмаас Сюйг «Пролетарийн штаб»! руу «хортойгоор дайрч давшлаа» гэж зэмлэхийг тэр үед хэн мэдэх вэ дээ?! Ер нь Сюй Мэнци түүний шилдэг сайн найзын тархи толгой тэр аяараа ялзарсан юм байна гэдэг нээлтийг гэнэт хийснийг эс тооцвол тэр явдлаас хойш ч гэсэн байдал ноцтой болж байгааг тоож үзээгүйгээр барахгүй ямар ч дүгнэлт хийгээгүй явжээ. Тийм ч учраас анхны «шүүмжлэх цуглаан дээр Сюй өөрийнхөө зөв зүйтэйг сэтгэл тайван ул үндэстэй бөгөөд ухамсартайгаар хамгаалж байжээ».

- Яо Вэньюань тэр үед жирийн нэг редактор байсан. Түүнийг сүүлдээ ингэж эрх тушаал ахина гэж хэн яаж урьдчилан мэдэх юм бэ?! Үүнд дайрч давшилсан юу байгаа юм бэ!?. Харин Яо Пэнзы урван тэрслэгч байсан гэдэг бол түүхийн баримт юм. Би яалаа гэж худлаа хэлэх билээ? Хэрэв үнэмшихгүй бол би Лу синий зохиолыг олж ирээд та нарт чанга дуугаар уншаад өгье. Эцэг нь эцгээрээ хүү нь хүүгээрээ байгаа юм чинь «пролетарийн штаб руу» дайрч давшилсан юм огт байхгүй...гэж хэлж байжээ.

Өөрөө өөрийгөө зөвтгөсөөр дахиад бас нэг «хортой дайралт» хийж байна гэдэг бодол Сюйгийн тархи толгойд ч орсонгүй! Сюй Мэнциг «Эрх тушаал ахисан» гэдэг хортой томьёолол хэрэглэлээ гэж «тэмцэх цуглааныг» угсраагаар таван удаа хийжээ! Дараа дараачийн цуглаан дээр түүгээр үг ч хэлүүлсэнгүй, түүний урьд хэлсэн үгийг байлцсан хүмүүс ч бас мэдэлгүй өнгөрчээ. Ердөө л: «Нам ба социализмыг галзуурсан мэт дайрч, пролетарийн штаб руу давшилсан. Энэ этгээдийн хортой үгийг дэлгэрүүлэхгүйн тулд түүний тодорхой утгыг энд давтах шаардлагагүй» гэж мэдэгджээ. Харин ашгүй түүнийг баривчилж, шүүхэд шилжүүлсэнгүй өнгөрчээ. «Тэмцэл, шүүмжлэл» хэмээх нэртэй хэд хэдэн хурал хийсний дараа Сюйгийн хуучин найз сая «өршөөлийн мутраа сунгахаар» шийдвэрлэж, «антагонист зөрчил» гэдэг томьёолол нь «ард түмний доторхи зөрчил» гэгчээр солигджээ. Гэвч Сюй «хувьсгалын эсэргүү» гэсэн пайзтайгаа үлдэж түүнийг хэлтсийн даргаас цэвэрлэж, намын батлахыг нь хурааж, хошууны хувьсгалт хорооны байгууллагын хяналтад ажиллах ёстой болжээ. Харин Вангийн хувь заяа шал өмнөөгөөр шийдэгдэж, нилээд хэд хоногийн дараа хошууны хувьсгалт хороонд кадрын асуудлаар зөвлөлгөөн хийх үед гаднаас ирсэн дарга нарын нэг нь ревизионизмыг шүүмжилж, хувь хүмүүсийг намнах тухай хэлэлцэх явцад гэмт этгээдийн шилдэг найзын илрүүлсэн «хувьсгалын эсэргүү хэргийг» жишээ болгон дурдчихжээ. Тэгтэл бас аз дайрна гэгчээр мужийн хувьсгалт хорооноос хуралдуулахаар томилогдож ирсэн заофанийн (самуун дэгдээгчдийн) ямар нэг хэргэмтэн нөгөө ирээдүйтэй хүнийг олж хараад мань даравгар Ваи хошууны «хувьсгалт хорооны» даамал болчихдог байжээ.

Сюй Мэнциг ялаа эдлэж ажил хийж байх хооронд түүний эхнэр Ли Шуйжу, охио Сю Сяоцин хоёрыг бас тал талаас нь урж идчих гээд амар заяа үзүүлсэнгүй. Тэд «үхдэлийн бригад» гэдэгт өдий төдий хоног байж, «эрхэм нандин ариун шударга ёсны үүднээс ураг төрлийн хэлхээ холбоогоо таслахыг» тэдэнд тулгажээ. Бригадад байхдаа тэр хоёр нөхөр, эцгээсээ «холдож хөндийрнэ» гэж ам өчиг өгсөн боловч Сюйгийн талаар

ямар ч шинэ материал нэмж мэдүүлээгүй өнгөрчээ. Гэсэн ч сүүлд гэрийн хэн нь сав л хийвэл бригадад байснаа уйлан чарлан дурсаж, Сюйгийн чалчаа хэлнээс боллоо гэж түүнийг дуу нийлүүлэн зэмлэдэг болжээ. Урьдын найрсаг сайхан гэр бүл өдөр болгон хэрэлдсээр бантантай таваг шиг бут үсрэн асгарчээ.

Сюй Мэнци ханзны өнцөг сандайлан:

--Энэ хэл, миний энэ хэл үү! Би яах гэж чалчав даа?! гэж үглэж суудаг болжээ. Гэхдээ жинхэнэ учрыг нарийн тунгааж үзвэл түүний гэм буруу нь чухам юунд байна вэ? Бидэнд хэл зөвхөн идэж уухын тулд заяасан гэж үү?!,

Одоо ч гэсэн «...хувьсгалын эсэргүүд» тооцогдсоор байгаа болохоор өдөр бүр хогийн шүүр сугавчилсаар хошууны хувьсгалт хорооны байгууллагад очиж, жорлонг нь цэвэрлэж, хашааг нь шүүрдэх ёстой учраас Сгой урьдын адил нямбай гэгч хувцаслаж, сахлаа толийтол хусч, гэм буруугүй хүн гэдгээ улс амьтанд бүх байдлаараа харуулах гэсэн юм шиг ажиг ч үгүй цэмцгэр явдаг байв.

Тэгтэл дотор өрөөнөөс түүний хорин настай охин Сюй Сяоцин гарч иржээ. Охин нь хөдөөгийн залуучуудын тулгуур тасгийн «атрын тариалангийн бригадын» даргаар ажилладаг байжээ. Тэр үед дээд сургуульд окутан элсүүлэх зарлал гарахын өмнөхөн түүнд бүртгүүлэхийн тулд ядуу, ядуулаг дунд тариачдын саналыг авдаг журамтай байв. Ядуу ядуулаг дунд тариачид Сюй Сяоцины хувийн зан чанар, ажил, соёлын түвшнийг харгалзан «залуу бүсгүй Сюй Сяоцинд бид зуун хувь итгэж байгаа учир түүнийг дээд сургуульд элсч суралцахыг зөвшөөрч байна» гэсэн тогтоол гаргажээ. Өөрийг нь хошууны комисс сургуульд явуулахаар баталсан эсэхийг мэдэхээр Сюй Сяоцин урьд орой нь залуучуудын тулгуур тасгаас буцаж иржээ Сюй Мэнцигийн ганц охин үүний урьд эцгийгээ хүндэтгэж, нарт ертөнцийн аугаа их суут хүн мэтээр үздэг байсан бол одоо түүнийг арай хувьсгалын эсэргүү гэж үзэхгүй боловч харилцах байдал нь шал өөр болжээ. Өрөөнөөс гармагц шууд эх рүүгээ хандаж:

-Ямар ч атугай хошууны «элсэлтийн комисст» очёе. Харин батлагдах нь уу, үгүй юу, бүү мэд гэв.

-Чамайг чинь ядуу, ядуулаг дунд тариачид зөвшөөрсөн шүү дээ?! Харин соёлын түвшнийг чинь шалгавал давах уу, үгүй юу? гэж эх нь асуув.

-Уг нь саад болохоор юм алга л даа. Гагцхүү ааваас л болж балрах бий гэж айж..гэж охин нь үгээ дутуу хэлсэн боловч дэргэдээ байсан эцгийгээ яг л модон хувин буюу вандан мэт үзэж, хүний урамд тоож ч харсангүй.

Энэ үгийг сонсоод эх нь биеэ барьж тэссэнгүй:

-Уг нь уг нь гэнэ шүү! Одоо яагаад болдоггүй юм бэ! Ингэхэд наад сайхан «аавыгаа» муулж бай гэж чамайг хэн гуйсан юм бэ?! гэж уцаарлав.

Эхнэрийн ширүүн харц Сюйг шөвөгдөх шиг болж, ханзны өнцөг дээр газар ширтэн духуйж суусан Сюй эхнэрийнхээ өөдөөс эгцлэж харж ч чадсангүй.

Больхи доройг нь улс амьтад үзүүлэхээс илүү жигшүүртэй муухай юм байдаггүй болохоор Сюйн хамаг бие дахиад дагжиж эхлэв. Авгайнхаа нүдэнд хариугүй муу атигар амьтан болж хувирснаар барахгүй. охиныхоо өмнө үг дуугүй өвдөг сөгдөхөөс өөр аргагүй болж байгааг ойлгов. «Ээ чааваас, ээ чааваас, хамаг юм надаас л боллоо. Ямар золиг хэл амыг минь татаж чангаав даа? Өөрөө хувьсгалын эсэргүүд холбогдох бас авгай охин хоёроо хэрэг төвөгт оруулсан байх нь гэж бодмогцоо бушуухан босч, хоолтой поолуу өдөр тутмын ажлын багаж-хогны шүүр хоёроо сугавчлаад, гүйж гарлаа.

Сюй Мэнци хоёр эгнээ ганц дан бяцхан байшингуудын дундуур гарсан хавчиг гудамжаар тахиралдан явсаар төдхөн гол гудамжинд орлоо. Намар оройн цаг байсан учраас гудамжны хоёр талын шарласан модны навчис хүйтэн салхи үлээхэд мултран хийсч унана. Хүйтэн агаарыг хэд гүнзгий амьсгалаад Сюй Мэнцигийн дотор нилээд уужрах шиг болов. Хошууны бяцхан хотын гол гудамжаар тал талаас ажилдаа яарсан ажилчид, албан хаагчид алхацгааж явдаг цаг байв. Түүнийг гол гудамжаар ороод хэд алхтал араас нь морин тэрэг гүйцэж очлоо. Тэрэгний урд дээр «үүрийн туяа» хэмээх бага сургуулийн захирал Чжоу Тун суучихсан ташуураа савчин морио ороолгож явав. Тэргэндээ сурагчийн ширээ, самбар баахан дэвтэр цаас овоолон ачжээ. Сюй Мэнци урьд хошууны ардын боловсролын хэлтсийн эрхлэгч байсан болохоор Чжоу Туныг сайн таньдаг байлаа. Хошууны «соёл-гэгээрлийн фронтод» Сюйг «Хувьсгалын эсэргүү гэж шүүмжилж» байх үед Сюйд шинэ шинэ ял хүлээлгэхийг оролдож байсан бусад хүмүүсээс захирал Чжоу зөвхөн өөрийн бодож санаж байгаа зүйлээ ярих төдийгөөр өнгөрч байснаараа эрс ялгаатай байжээ. Тийм хэцүү цагт тэгж байна гэдэг амаргүйг Сюй Мэнци ч гадарлаж байв. Гаднын хүмүүс байхгүй үед захирал Сюйгээс «зугатаж буруулахыг» бодохгүй, харин «юм болгонд сэтгэлээр битгий шанал, тэгсхийгээд өнгөрнө биз...» гэж тайтгаруулдаг байжээ. Тэгээд ч түүнийг Сюй бузгай сайн санаатай хүн юм гэж үздэг байжээ.

Захирал Чжоу морио хэд ширүүн ташуурдаад Сюй Мэнцитэй зэрэгцэж ирлээ. Сюй эргэж хараад, нүүр халз учрахад:

--Сургууль нүүж байгаа юм уу? гэж асуулаа.

-Нүүхээс биш яах вэ дээ? Тэнд чинь манай хошууны шинэ данжаад чиний нөгөө хуучин найз өргөө харшаа барих юм байх. Ойр хавилцаа нь сургууль байвал үймж шуугина гэнэ Долоо хоногийн дотор зайлуул гэж тушаасан. Данжаадын өргөө харшийн дэргэдэх айлуудыг ч бас нүүлгэх юм байх, «Ангийн ширүүн тэмцлийн» одоогийн үе шатанд сайн ажиллахын тулд ингэж байх шаардлагатай болсон гэнээ... гэв.

-Тэр даравгар Ванг зусардаж долигоносон амьтан алга! гэж Сюй тэсэлгүй ам алдав.

-Тэр ч тун өөдгүй амьтан шиг байна...

Энэ яриа Сюй Мэнцигийн хор шарыг аажмаар хөдөлгөв. Сюй бол шударга биш явдалтай тулгарвал ам хэлээ барьж байж чаддаггүй зантай төрсөн хойно яая гэхэв.

-За гайгүй! тэр золиг өнөөдөр «капиталист замаар» замнагчидтай, маргааш болоход «эрхтэн ямбатны давхаргаатай» тэмцэлдэж л байг. Ингэхэд тэр өөрөө чухам хэн юм бэ? Миний бодлоор «Шинэ язгууртан» л байж таарна! Олон түмэнд өчүүхэн ч атугай үнэнч хүн ийм хэрэг үйлдэх үү дээ?! Манай хошууны эрх мэдэл иймэрхүү хүмүүсийн гарт орсон цагт ажил хэрэг өөдлөх үү дээ? За яавал яаж л байг!

Гэтэл урт чих газар сайгүй байдаг байжээ. Хөлийн чимээнээр Сюй Мэнци эргэж хартал яг ард нь нэг горзгор өндөр амьтан бараг наалдчихсан явж байв. Харахнаа нь урьд хошууны ардын боловсролын хэлтсийн ажилтан байсан, «дайлан илжиг» хочтой Гао Пиньдэ байв. Тэр нь даравгар Вангийн мөрөөр орж, хавь ойрынхоо хүмүүсийг хадарч зайлуулаад Сюйгийн оронд боловсролын хэлтсийн эрхлэгч болсон юмсанжээ.

Хэлтсийн шинэ эрхлэгч Сюй Мэнцигийн үгийг сонсмогц:

-Зогс наанаа, тэнэг үхээр! гэж зандарлаа. Энэ дашрамд хэлэхэд «шүүмжлэл тэмцэл» явагдаж байх үед Гао хуучин эрхлэгчийгээ овог нэрээр нь дуудаж байгаагүйгээр үл барам тэнэг үхээр хорт могойн сүнс»

гэж гүйцэд хэлэхээс ч төвөгшөөж ердөө л «тэнэг үхээр» гэж хэлбэл яг таарна гэж боддог байжээ.

Сюй Мэнци зогслоо.

Гао Пиньдэ палгар том биеэрээ хэрж очоод ууртай харцаар хялвалзан ширтэж:

-Сая чи энд юу гэж хэлэв ээ? гэв.

-Би юу ч хэлээгүй.

-Юу ч хэлээгүй гэнээ?! гэж Сюйг дооглон агсарав.

-Чи нэгтэй л цөмийг нь сонссон юм бол асуух хэрэг байна уу?

-Чи үнэнээ хүлээж байгаа бол болох нь тэр! гээд сургуулийн захирал руу харж «Чжоу чи энд хувьсгалын эсэргүү этгээдтэй хамтарч, дайралтынхаа үзүүрийг улаан засгийн эсрэг чиглүүлж, Ван даргыг дайрч давшилсаныхаа улс төрийн хариуцлагыг хүлээх болно доо. Одоо та нар миний гараас гарахгүй гэж мэдээрэй!» гэж занав.

Ингэж хэлчихээд Гао цааш хэнэг ч үгүй салж одов.

Хяналт хараанд орсон «Хувьсгалын эсэргүү этгээд» Сюй Мэнцигийн өдөр тутмын зорилт нь хошууны хувьсгалт хорооны жорлон, хашааны хог шороог цэвэрлэх ажил байв. Хашаа нь бага, мод зай завсаргүй ургасан тул нимгэн салхи жаахан л үлээхэд шарласан навчис газраар нэг хуйлран хийсч, түүнийг Сюй зогсоо завгүй дахин, дахин шүүрдэнэ. Хамаг биений нь хөлс асгаравч сэтгэл зүрхнийхээ хамаг шаналгааг нэгмөсөн шүүрдэж арилгах гэсэн юм шиг тасралтгүй шүүрдсээр л байна. Хашаагаар нэг тоос шороо манарахад нэг цзао фань (самуун дэгдээгч) санаатайгаар шороо бужигнууллаа гэж зэмлэж ч байв. Гэвч Сюй шүүрдсээр л байв. Харин тэглээ гээд сэтгэлийн шаналгаа нь харин ч бүр тэсэж байхын аргагүй болсоор байв. «Би яахлаараа хэл амаа барьж чаддаггүй юм бэ?! хэлнээсээ болж «хувьсгалын эсэргүү» гэж зарлагдсан маань багадлаа гэж үү? Шударга ёс байхгүй болохоор нь хэл амаа билүүдэж эхлэх юм. Ер нь засаршгүй зантай хүн юм!» гэж гиюүрч шаналав.

Үд өнгөрч таван цаг болж Сюй Мэнциг шүүрээ сугавчласаар харихад эхнэр нь аль эрт ажлаасаа ирчихсэн хоол унд хийж байв. Ам нь хатаж хуурайшсан Сюй шүүрээ байшингийн буланд хаячихаад ханзан дээр гарч хажуулсныг эхнэр нь ч тоож анзаарсангүй, Одоо ч бүх юм баларч гүйцлээ гэж бодмогцоо Сюй босч цонх руу очиж амаа ангайлган хэлээ толинд харав. Хэлний нь хүрэн бор өнгөр улам зузаарч, эхэр, гашуун юм амтагдана Шүдний сойзтой аяганаас хусуур авч хоол идэхийн өмнө хэлээ цэвэрлэх гэж байтал гаднаас охин нь орж ирлээ.

Эх нь угааж байсан ногоог түр тавьж их л сонирхсон байдлаар:

-За, институтын талаар тодорхой юм дуулдав уу? гэж асуув.

-Намайг оруулаагүй байна! Эцэг маань хувьсгалын эсэргүү болохоор хамаг юм дуусдаг юм байна! гэж хэлчихээд ханзан дээр түрүүлгээ харж хэвтэн орилж гарав.

-Хараач чи! Чамаас л хамаг юм болж байна! гэж эхнэр нь Сюйг дахиад хялалзан үглэж эхлэв. Сюй Мэнци өөрийн бурууг ойлговч

-Хоёр үг хэлчихснээс өөр миний буруу нь юу байна? гэж өөрийгөө зөвтгөх гэж оролдож үзлээ.

-Тэнд ч хоёр үг, энд ч хоёр үг чалчсаар байгаад амьдралаа үрж, чамаас болж эхнэр, хүүхэд чинь зовж тарчлаж байна! гэж хэлээд эхнэр нь бас уйлж эхлэв.

-О-о гэж охин орлино.

-О-о гэж эхнэр орилно.

Тэгтэл гэнэт хаалга түр няр хийж, «далайн илжиг» тэргүүтэй гурван хүн орж ирлээ. Тэд Сюйг хүрээлж уур хилэн бадарсан догшин харцаар шилбүүрдэж:

-Тэнэг үхээр чи сайхан мэдээрэй! Цагаандаа гарсан хувьсгалын Эсэргүү чи, буруугаа гэмшихийн оронд улааны засгийг довтолж хошууны хувьсгалт хорооны удирдах нөхдийг элдвээр муучлаж, шившигтэй гэмт хэрэг өдүүлснийг гурван үеийн хорооны төлөөлөгчид бид чамд мэдэгдэх гэж ирлээ! Маргааш кино театрын байранд шүүмжлэл, тэмцлийн цуглаан хийнэ! Оройн найман цагт ганц ч минут хожимдолгүй очсон байгаарай! Хэрэв хожимдвол түүний хамаг хариуцлага чамд оногдоно! гэж зандчив.

Үүнийг дуулгачихаад тэр гурав хуй салхинд үлээгдсэн юм шиг гүйлдэн гарав.

Шинэ аюулд ниргүүлсэн эхнэр нь хэсэг зуур таг чиг алмайрч байснаа нөхөр нь дахиад л цөмөөрөнг баллах ямар нэг аюумшигтай гай тарьсныг сая ухаарч ойлгов. Тэгээд Сүйг хуруугаараа чичлэн:

-Чи чинь бас л чалчиж, хэрэг тарьсан байх нээ?! гэж хашгичаад, уурандаа саяхан угаасан яншууг авч өвгөнийхөө нүүр лүү шидлээ. Ногоо шал дээр бутран ойчиж, Сүйгийн нүүрэн дээр усны дуслууд бөнжигнөж үлдэв.

Эхнэрийнхээ ингэж муухай аашлахад зэвүү нь хүрсэн Сүй:

- Би юу хэлж орхиов? Би үнэнийг л хэлсэн гэж зандрав.

-Үнэнийг, үнэнийг гэнэ шүү! Муу адсагаа бүтэн авч явья гэж бодвол наадахь болдоггүй хэлээ тас хазаад залгиж орхисон чинь дээр бий!

Эхнэрийн нь энэ үг Сүйгийн зэвүүг бүр ч хүргэлээ, «Хамаг юм миний хэлнээс болж, гай зовлон тасрахгүй мянга түмд хүрлээ. Хамаг муу юм энэнээс болж байгаагаас хойш би ч гэсэн эрээлж цээрлэхээ больё» гэж бодоод Сүй:

-За яахав, яахыг минь чи одоо харах ч!...гэж эхнэрийгээ зандарлаа.

Тэгээд зүүн гараараа хэлээ татаж, баруун гараараа цонхон дээр хэвтэж байсан сахлын хутгыг шүүрч авав...Тэгтэл Сүйгийн амнаас улаан цус олгойдов. Эхнэр, охин хоёр нь айсандаа эхлээд хөдлөж чадахгүй мэлэрснээ, ухасхийн очиж:

-Чи яаж байгаа нь энэ вэ?!

-Аав аа, аав минь! гэж орилолдов.

х х х

Ийм нэгэн түүхийг далан хоёр онд надад хүн ярьж өгсөн юм. Энэ түүхийн гол хүн бол Линь Бяо болон «дөрвөн дээрэмчний» тамлаж алсан хүмүүстэй зүйрлүүлэхэд шалихгүй юм.

Ерөөсөө ч баатар биш гэдэг нь уг хэрэг яаж шувтарч байгаагаар харагдаж байна. Тэглээ ч гэсэн би энэ тохиолдлын тухай, ардчилал, үнэн шүүх гээч хаана байна вэ?! гэдэг тухай зүрх шимширэхгүйгээр дурсаж чадахгүй юм.

(«Ялузян» сэтгүүл, 1979, № 6)

Орос хэлнээс орчуулсан Д. Базаргарьд.